



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/523

Мандалговь

Г Ноос бэлтгэн нийлүүлэх тухай Г

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.1, Гурван тулгуурт хөгжлийн бодлогын 3.1.2.3, 3.1.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Манай аймгийн хонины ноос "ноолуур"-ын хольцтой нь тогтоогдон үйлдвэрийн стандартыг бүрэн хангасан үнэт түүхий эд болоод байгаа тул аймгаас бэлтгэгдсэн хонины ноосыг өөрийн орон нутаг дахь малчдын хоршоогоор дамжуулан үндэсний үйлдвэрт нийлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж анхаарч ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Хоёр. Ноосны нийлүүлэлтийн талаарх тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд жил бүрийн 8 дугаар сарын 1-ны өдрийн дотор танилцуулж ажиллахыг Сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

438010619

